МЭДЭЭ · 2022 оны 10-р сарын 5

800 ОРЧИМ ОЮУТАН, СУРАГЧДАД ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ТАЛААР МЭДЭЭЛЭЛ ӨГЛӨӨ



Өвөрхангай аймгийн прокурорын газраас тус аймгийн Арвайхээр сумын ерөнхий боловсролын Мэргэд, 1, 2, 4, 5 дугаар сургууль, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 800 орчим сурагч, оюутан, багш нарт хууль, эрх зүйн мэдлэг олгох, сургалтыг зохион байгууллаа.

Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлийн хорирогч болохоос урьдчилан сэргийлэх зорилготой тус сургалтаар Хүүхдийн эрхийн тухай хууль тогтоомжийн талаар болон аймгийн хэмжээнд гарсан хүүхэд хохирсон, холбогдсон гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдлын талаар мэдээлэл өгсөн байна.